

СОЁМБО МЭДЭЭ

Өнөөдөр

ЦЭРГИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨГӨӨН БОЛЖ БАЙНА

ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсээс Цэргийн албаны зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Тус зөвлөгөөнд ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Төрлийн цэргийн командлалууд, Барилга инженерийн цэргийн

удирдах газрын цэргийн алба, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан албан тушаалтнууд оролцож байгаа бөгөөд Зэвсэгт хүчний цэргийн албаны байдалд дүгнэлт хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал бодлоо солилцож байгаа юм.

Маргааш

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

"Зэвсэгт хүчин-100" эрдэм шинжилгээний бага хурал ҮБХИС-д зохион байгуулагдана.

САНСАР СУДЛАЛ БА САНСРЫН ТЕХНОЛОГИ

Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн хүрээнд "Сансар судлал ба сансрын технологи" эрдэм шинжилгээний бага хурал ШУА-ийн төвд болно. Тус хуралд Монгол хүн сансарт ниссэний болон сансарт хамтран ниссэний 40 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх комиссын дарга, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцоно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР

ЗАЛУУСЫГ АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ БОЛОХОД НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ

Засгийн газрын ээлжит хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр боллоо. Хуралдаанаар "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх" төслийг баталлаа. Багц сургалт нэг сарын хугацаатай. Сүүлийн гурван сар ажилгүй байгаа ч ажил хийх, амьдралаа өөрчлөх хүсэлтэй, 18-34 насны, эрэгтэй, эмэгтэй 1000 хүнийг сар бүр сонгон шалгаруулж, тус бүр нэг сая төгрөгийн тэтгэлэгтэй сургах юм Төслийн талаарх мэдээ, мэдээллийг бүртгэл эхлэхээс 10, түүнээс багагүй хоногийн өмнө нийтэд зарлан мэдээлнэ. Залуучууд тухайн үед нь цахимаар болон өөрсдөө очиж бүртгүүлэх боломжтой. Бүртгэлийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн

газар, хэлтэс хариуцах юм.

Бүртгэх, ярилцлага хийх, сонгон шалгаруулахтай холбоотой удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Сонгон шалгаруулалт, цар тахлын шинжилгээ, эрүүл мэндийн бусад үзлэгт тэнцсэн залуусыг нэгдсэн цэгээс багц сургалт хийх байранд хүргэнэ. Орон нутгийн залууст унааны зардал олгохоор төлөвлөжээ.

Төсөл нь залууст эрүүл, эртэч, амьдралын идэвхтэй хэв маяг, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх хэлбэрээр ажилтай, орлоготой болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ хүрээнд өөрийгөө танин мэдэх, зөв дадал хэвшил, харилцаа хандлага, эх оронч үзэл санааг ойлгуулж,

бие бялдын зөв хүмүүжил, гэр бүлийн эерэг харилцаа, соёл төлөвшүүлэхэд чиглэсэн багц сургалт явуулна.

Мөн ажил хөдөлмөрт бэлтгэх, ажлын ачаалал зэргийг даван туулах цадавхд сургах, хүн бүрийн онцлогт тохирсон ажил, мэргэжлийн зөвлөгөө өгч, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө гаргахад нь туслах юм.

Энэ жил шаардагдах 11 тэрбум 800 гаруй сая төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын батлагдсан төсвийн багцаас зохицуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан санхүүжүүлнэ. Төсөлд хамрагдсан залуусыг нэг жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажилтай болгосон ажил олгогч, ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон нэг

жилийн Нийгмийн даатгалын шимтгэл /эрүүл мэндийн даатгалын шимтгэл орохгүй/-тэй тэнцэх нэг удаагийн нөхөн олговор олгохоор төлөвлөв. Үүнд шаардагдах хөрөнгийг 2022 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байх юм.

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ хийхдээ залуучуудыг ажилтай болгох талаар тусгаж байхыг төсвийн бүх ерөнхийлөн захирагчид даалгалаа. Нийт хүн амын 31, хөдөлмөрийн насны иргэдийн 46 хувийг 15-34 насны залуус эзэлдэг. Улсын хэмжээнд ажилгүй байгаа 92 мянга гаруй хүний 51 хувь нь буюу 47 орчим мянга нь 18-34 насныхан гэсэн статистик мэдээ гарчээ.

Эх сурвалж: Zasag.mn

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
4°C	-10°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
42°C	28°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
10°C	2°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,351.0	3,416.0
CNY	433.20	438.00
RUB	37.49	39.21
JPY	25.85	26.49
KRW	2.44	2.56

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	109
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3481
ЭДГЭРСЭН	2797
НАС БАРСАН	7

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	17
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	174
ЭДГЭРСЭН	863

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.11 /ПҮРЭВ ГАРАГ/

ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БАР САРЫН НЭГ ЦАГААН МОРЬ ӨДӨР

Үс засуулвал:
Хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх:
07.13-18.51

Барилдлага: Үл зохилдох Шүтэн барилдлага: Тийм мэдэхүй Суудал: Мод

Аргын тооллын 3 сарын 11, Бархасвадь гараг. Билгийн тооллын 28, Тооно одтой, шар морь өдөр. Өдрийн наран 7 цаг 13 минутад мандан, 18 цаг 51 минутад жаргана. Тухайн өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

АЖЛЫН ХЭСГИЙН АНХНЫ ХУРЛААР...

Батлан хамгаалахын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлөг, улсын болон иргэний нисэхийн нислэгийн хөдөлгөөний мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ бий болгох асуудлыг судлах, холбогдох тооцоо, судалгаа, дүгнэлт гаргах ажлын хэсэг анхны хурлаа өчигдөр цахимаар хийлээ.

Цахим хуралд ажлын хэсгийн дэд дарга, Батлан хамгаалахын сайдын зөвлөх, хурандаа Б.Эрдэнэбат, нарийн бичгийн дарга, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Б.Энхзоргол, БХЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хуулийн зөвлөх Г.Энхболд, Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн тэнхимийн багш, бэлтгэл хурандаа С.Отгонбаяр болон ИНЕГ-ын дэд дарга Б.Алтанцом, АННББЗГ-ын дарга Д.Эрдэнэбаатар, ИНҮТ-ийн дарга П.Мөнхжаргал болон бусад гишүүд оролцож, ажлын хэсгийн төлөвлөгөөг хэлэлцлээ. Ажлын хэсэг санал, дүгнэлтээ энэ сарын 31-ний дотор багтаан Батлан хамгаалахын сайдын зөвлөл, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанд тус тус танилцуулах юм.



ЖАНЖНЫ СЭЛЭМТ НАЙРАГЧААР М.АМАРХҮҮ ТОДОРЛОО

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүссэний 110 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй "Эх орны цэрэг 2021" яруу найргийн наадамд 191 яруу найрагчийн 402 бүтээл ирснээс Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагч М.Амархүүгийн бүтээл түрүүлж, Жанжны сэлэм гардлаа. Яруу найрагч М.Амархүү ийнхүү "Эх орны цэрэг" яруу найргийн наадмын хошой тэргүүн шагналт болж байгаа юм. Наадмын тусгай байрт яруу найрагч А.Лхагва, Д.Жамбалдорж, гутгаар байрт Н.Гантулга, хоёрдугаар байрт Н.Минжинсайхан нар шалгарлаа.



"Эх орны цэрэг 2021" яруу найргийн наадам уламжлал ёсоор 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ангиудын байлдааны тугийг хүндэтгэн залснаар эхэлж, 1 шатнаас тунаж үлдсэн шилдэг 25 найрагч шүлэг найргаа уншиж өрсөлдлөө.

Наадмын Ерөнхий шүүгчээр Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, "Болор цом"-ын эзэн, яруу найрагч Тангадын Галсан, шүүгчээр Төрийн шагналт, Ардын уран зохиолч Дөнгөтийн Цоодол, Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, "Болор цом"-ын эзэн, "Эх орны цэрэг" яруу найргийн анхны наадмын Тэргүүн шагналт, Жанжны сэлэмт яруу найрагч Дамбын Төрбат, Төрийн соёрхолт яруу найрагч Цогдоржийн Вавуудорж, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш, Утга зохиол судлаач, хэл бичгийн ухааны доктор Гончигийн Батсуурь нар ажилласан юм.

Наадамд оролцсон 191 яруу найрагчийн дотор Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн 31 (үүнээс "Эх орны цэрэг" яруу найргийн наадмын шагналтан 5, "Болор цом"-ын эзэн найрагч 3), Ахмад хилчин, ахмад дайчдын төлөөлөл 2, Зэвсэгт хүчний анги, байгууллагаас 85 (үүнээс байлдагч 32, ахлагч 32, офицер 21, БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагч 2), Цагдаагийн алба хаагчдын төлөөлөл 1, Ерөнхий боловсролын сургуулийн сурагч 2, БНСУ-аас оролцогч 2, чөлөөт уран бүтээлч 68 хүн байлаа.

Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга хамтран 1989 оноос зохион байгуулж буй энэхүү наадмыг "Болор цом"-ын энтэй томоохон наадам хэмээн үнэлдэг бөгөөд шүлэг найраг сонирхогчдоос эхлээд мөрддэстэй уран бүтээлчид, Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагчид, Төрийн шагналтнууд, Ардын уран зохиолчдын оролцдог нэн хүндтэй найргийн дэвжээ болон өргөжсөн билээ.

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР

“АЛАГ МОРЬТОЙ ДАНДАР БААТАР”, “1921 ОНЫ ХУВЬСГАЛ”, “ЯЛАЛТЫН ТУХАЙ” ШИЛДГЭЭР ШАЛГАРЛАА



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабаас Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабуудтай хамтран “Монгол Улсын Зэвсэгт хүчин-100” сэдэвт гар зургийн уралдааныг оюутан, сурагчдын дунд зохион байгууллаа. Гар зургийн уралдаан хоёр сарын хугацаанд явагдсан бөгөөд нийслэлийн есөн дүүрэг, 21 аймгаас 800 гаруй оюутан, сурагчид бүтээлээ ирүүлсэн нь уралдааны цар хүрээ, ач холбогдлыг илтгэн харуулж чадсан юм.

Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг дүрслэх урлагийн мэргэжлийн багш нараас бүрдсэн шүүгчид шалгаруулж, сэдэв, агуулгаа бүрэн гаргасан

эсэх, зурах ур чадвар, зургийн хэрэгсэл ашигласан байдлыг харгалзан ерөнхий боловсролын сургуулийн бага (6-10 нас), дунд (11-14 нас), ахлах (15-18 нас) ангийн сурагчид, их, дээд сургууль, коллежид болон дүрслэх, урлагийн мэргэжлээр суралцаж байгаа оюутан, сурагчид гэсэн 5 ангиллаар тус бүр шилдэг 3, нийт 15 бүтээлийг шалгаруулсан юм. Мөн шагналт тусгай байрууд буюу ангилал бүрээс 10, нийт 50 гар зургийг шалгаруулан “Монгол цэргийн музей”-д 3 дугаар сарын 13-ны өдрөөс 3 дугаар сарын 17-ны өдөр хүртэл дэлгэж, оюутан, сурагчдынхаа туурвисан монгол цэргийн тухай өгүүлэх гар зургийг олон нийтэд хүргэж, шилдэг 100 гар зургаар зургийн альбом бүтээж, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудад тараахаар ажиллаж байна.

Уралдааны тэргүүн байрыг Төв аймаг, Зуунмод хотын “Хүмүүн цогцолбор” сургуулийн 5 дугаар ангийн сурагч Ө.Мөнхжин (бага анги, 6-10 нас), Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Сингапур” сургуулийн 8 дугаар ангийн сурагч Э.Батхшиг (дунд анги, 11-14 нас) “Алаг морьтой Дандар баатар” бүтээлээр, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Титэм” сургуулийн 10 дугаар ангийн сурагч П.Натаймолон (ахлах, 15-18 нас) “1921 оны хувьсгал” бүтээлээрээ, их, дээд сургууль, коллежид болон дүрслэх, урлагийн мэргэжлээр суралцаж байгаа оюутан ангилалд ШУТИС-ийн дөрөвдүгээр дамжааны оюутан А.Лиона, СУИС-ийн дөрөвдүгээр дамжааны оюутан Н.Гончигсумлаагийн “Ялалтын тухай” бүтээлүүдээрээ тус тус эзэллээ.

“ЧАДВАРЛАГ-100”-ГААС ШИЛДЭГ 9



Зэвсэгт хүчин хэмээх их айлын хот хөдөө, хол ойрын хамаг л ажлын голыг нугалахад 089 дүгээр анги тэр тусмаа эл ангиар овоглогдсон алтан шар замын эзэд, авто техникийн жолооч нар голлох үүрэгтэй. Эгэл атлаа энгүй үүргийг нуруундаа үүрч яваа тус анги ирэх онд 100 жилийнхээ түүхэн ойтой золгох аж. Тиймдээ ч эдний хамт олон ангийнхаа их ойг угтаж басхүү Зэвсэгт хүчнийхээ 100 жилийн ойн хүрээнд аливаа ажил, арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлсээр байна. Тэдгээр ажлынх нь нэг болох 100 жолоочийг хамруулсан “Чадварлаг-100” тэмцээн өчигдөр ангийнх нь байрлалд боллоо. Ангийн захирагчийн орлогч, ахлах инженер, дэд хурандаа Д.Алтанбаяр эл тэмцээнийг санаачилж, зэвсэг, техникийн албаны хамт олон нь зохион байгуулсан юм. “Жолооч нарынхаа, тэр дундаа шинээр томилогдсон залуусынхаа мэргэжлийн ур чадварыг шалгах,

дээшлүүлэх, олон жил ажилласан, дадлага туршлагатай ах нараасаа суралцах, харилцан туршлага солилцох боломжийг энэ тэмцээн бүрдүүлж байгаа юм. Ийм ч зорилго агуулсан” гэж санаачлагч болон зохион байгуулагчид нь онцолж байв. Жолооны дүрмийн шалгалт, галын бэлтгэлийн 12, 13, 15 дугаар норматив, авто дромын элементүүдийг гүйцэтгэх гэсэн гурван даалгаврын хүрээнд оролцогчид авьяас чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм. Гурав дахь даалгавар буюу авто дромын элементүүдийг гүйцэтгэхдээ өрсөлдөгчид суудлын авто машин, автобус, ачааны буюу “Зил-130” маркийн машинуудаас дурын техникээр даалгавараа гүйцэтгэв. Тэмцээний төгсгөлд Д ангилалын төрөлд ахлах ахлагч Б.Энхтөр, ахлагч Т.Мөнхбаяр, Д.Ган-Очир нар, С ангилалын төрөлд ахлах ахлагч С.Норовваанжил, Б.Анхбаяр, ахлагч Т.Тэгшээ нар, В ангилалын

төрөлд дэд ахлагч Э.Амарбаатар, Б.Мөнхсүлд, ахлагч Э.Өвөө нар тус тус шалгарлаа.

Тэмцээн өрнөх үеэр тус ангийн техник шалган нэвтрүүлэх байрын дарга, ахлах механик, ахлах ахлагч С.Батбаяраас хэд хэдэн зүйл сонирхон асуув. Тэрээр ШУТИС-ийн МИС-ийг автын инженер мэргэжлээр 2001 онд төгсөөд 2013 онд эл ангид “бул нэмж” тэр үеэс л одоогийнхоо албан тушаалыг хашиж байгаа гэнэ. Тэдний гэр бүл бараг бүгдээрээ цэргийнхэн төдийгүй, түүний аавыг Ховдын хорооны захирагч асан хурандаа Н.Сайнбилэг гэдгээр нь салбарынхан анддаггүй аж. Харин ээж Д.Алтанцэцэг нь тус ангид насаараа усны тэрэг жолоодож, ахлах ахлагч цолоор мөрдэс гоёж явсан бүсгүй гэнэ. Аав, ээжийнхээ ажил, амьдралын замналыг түүчээлж, Зэвсэгт хүчинд алба хааж яваадаа бахархдаг нь түүний ярианаас илхэн.

С.Батбаяр ярианыхаа эхэнд “Манай жолооч нар үнэхээр чадварлаг, ажил, мэргэжилдээ эзэн нь болсон залуус” хэмээн тодоголоо. Түүний ажил өдөр бүр зургаан цагт эхэлдэг бөгөөд ангийнхаа хашаанаас ажилдаа гарч буй жолооч бүрт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөн эрүүл мэндийн байдлыг нь лавлахаас гадна машин техникүүдийн бүрэн бүтэн байдлыг нэг бүрчлэн шалгаж явуулдаг ажээ. Эндээс Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд цаг хугацаатай өрсөн өрнөж байгаа ямар ч ажлыг саадгүй бүтээхэд тус ангийн хамт олны үүрэг, хариуцлага, ажлын онцлог нь тод харагдах буй за.

ЦАХИМ ШУУДАНД

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦАХИМ БАГА ХУРАЛ БОЛОВ

ҮБХИС-ийн ЦНДС-ийн Цэргийн инженер, химийн тэнхимийн 2020-2021 оны хичээлийн жилийн “Орчин үеийн инженер, химийн техник, технологийн хөгжлийн чиг хандлага, түүнд хийх судалгаа” сэдэвт багш нарын эрдэм шинжилгээний онолын бага хурал боллоо.

Эрдэм шинжилгээний бага хурлаар “Зэвсэгт хүчний

“Инженерийн цэрэг”-ийн боловсон хүчнийг бэлтгэсэн түүхэн үе шат, өнөөгийн байдал”, “Батлах хамгаалах салбарт тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн лаборатори байгуулах боломж, түүний ач холбогдол”, “Цэргийн ус өргөх, шахах хэрэгсэлд нарны эрчим хүчийг ашиглах боломж, түүнд хийсэн судалгаа” зэрэг 8 илтгэлийг хэлэлцүүлсэн юм.

БУУДЛАГЫН АВАРГУУД ТОДОРЛОО



Нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нар энэ сарын 04-ний өдөр буудлагын анхны дасгал боловсруулж аваргуудаа шалгарууллаа.

Гар бууны төрөлд Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээг хариуцсан ахлах офицер, хурандаа М.Мөнгөнтулга, Налайх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын Мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч О.Батсүрэн, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын шуурхай байдлын ахлагч, сургагч ахлагч С.Цэндээсэм нар, галын бэлтгэлийн нормативын төрөлд, Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Л.Цэрэбаяр, Налайх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын Мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч О.Батсүрэн, мөн Цэргийн штабын шуурхай байдлын ахлагч, ахлагч О.Цэвээндөө нар тус тус шалгарлаа.

Дэслэгч Б.БАТЦЭЦЭГ

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭ СУРТАЛЧИЛНА

303 дугаар анги



Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний түүхэн ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, иргэд, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор урлагийн тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт бэлтгэж байна. Тодруулбал, 3 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн 10, 21 дүгээр хорооны байршилд иргэд олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа явуулах юм.

“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан ангийн удирдлага, эрэгтэй цэргийн алба хаагчдын зүгээс эмэгтэй цэргийн алба хаагчдаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Энэ үеэр урлагийн тоглолт сонирхуулж хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа.

Зэвсэгт хүчний түүхт 100 жил, анги үүсэн байгуулагдсаны 55 жилийн ойг угтан ангийн ахлагчийн зөвлөлөөс “Ангийн сүлд дууны шүлгийн уралдаан”-ыг зарлалаа. Тус уралдаанд шалгарсан дууны шүлгээр түүхт 55 жилийн ойгоор дуулагдах ангийн сүлд дууг бүтээж олны хүртээл болгох зорилготой юм.

Ахлах дэслэгч Г.БИЛГҮҮТЭЙ

ЦОЛ БҮХЭН САЙХАН

325 дугаар анги



Зэвсэгт хүчний 100 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтан амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын уралдаан тэмцээнээр дамжуулан цэргийн алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Цол бүхэн сайхан” гар бөмбөгийн аварга шалгаруулах бооцоот тэмцээнийг зохион байгууллаа.

Тус тэмцээнд хурандаа, дэд хурандаа, хошууч, ахмад, тэргүүн ахлагч, сургагч ахлагч, ахлах ахлагч, ахлагч, дэд ахлагч нарын нийт 8 баг хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс дэд ахлагч Т.Билэгсайхан, ахлагч Г.Мягмарсүрэн, ахлах ахлагч Ж.Жамъяндорж ахлагчтай багууд эхний 3 байрын эзэллээ.

Ахмад Н.МӨНХБААТАР



СОЁМБО СОНИН

“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг “Соёмбо”
сонини редакцал
бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029